

ШУА-ИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ВЬЕТНАМД АЙЛЧИЛЖ, ХҮРЭЭЛЭНГҮҮД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАВ

БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч Нгуен Суан Тханг тэргүүтэй төлөөлөгчид 2012 оны 05 сард манай улсын ШУА-д айлчилж, зарим хүрээлэнгүүдийн үйл ажиллагаатай танилцан, МУ-ын ШУА, БНСВУ-ын Нийгмийн ШУА хооронд шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд хоёр академийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин, Нгуен Суан Тханг нар гарын үсэг зурсан билээ. Ингэснээр манай хоёр улсын шинжлэх ухааны байгууллагууд хооронд хамтран ажиллах эхлэл тавигдсан юм. Энэхүү хамтын ажиллагааг үргэлжлүүлэх үүднээс БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч Нгуен Суан Тхангийн урилгаар ерөнхийлөгч Б.Энхтүвшин тэргүүтэй ШУА-ийн төлөөлөгчид 2012 оны 11-р сард БНСВУ-д хариу айлчлал хийлээ.

Манай төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ШУА-ийн дэд ерөнхийлөгч Т.Дорж, Гадаад харилцааны хэлтсийн дарга Л.Даваагив, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал Л.Хайсандай, Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Шүрхүү, эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал Б.Цогоо, Эрдэмтэн нарийн бичгийн дарга Л.Цэдэндамба нар багтсан юм. Айлчлалын үеэр хоёр академийн төлөөлөгчдийн албан ёсны уулзалт болж хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэх талаар санал солилцож, ойрын үед хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тохиролцон, 2012 оны 5-р сард Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан хамтын ажиллагааны гэрээнд зарим нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар шийдвэрлэв. Мөн уулзалтын үед БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэнгийн дэргэд Монгол судлалын төв, МУ-ийн ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн дэргэд Вьетнам судлалын төв байгуулах, жил бүр тодорхой сэдвээр эрдэм шинжилгээний хамтарсан хурал зохион байгуулах гэх мэт тодорхой асуудлуудыг хэлэлцэн тохиролцов.

ШУА-ийн төлөөлөгчид Вьетнамын НШУА-ийн Нийгмийн ухааны сургууль, Социологийн хүрээлэн, Угсаатны музейд зочилж, Хо Ши Миний бунхан, Хааны ордон гэх мэт Ханой хотын түүх дурсгалын газруудыг үзэж сонирхов.

Айлчлалын нэгэн чухал үр дүн бол Монгол, Вьетнамын хүрээлэнгүүд хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хамтран хийх ажлаа хэлэлцэн тохирсон явдал байлаа. Манай Олон улс судлалын хүрээлэн БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэн болон Хятад судлалын хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулав. Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Л. Хайсандай, БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Тран Куанг Минь, Хятад судлалын хүрээлэнгийн захирал, доктор, профессор До Диен Сам нар 2012 оны 11 сарын 23-нд Хамтын ажиллагааны гэрээнд тус тус гарын үсэг зурсан юм.

ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор

Б.Цогоо, БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Төвийн бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор Зыенг Ба Фыенг нар 2012 оны 11 сарын 28-нд хамтран ажиллах гэрээнд мөн гарын үсэг зурав.

Хамтын ажиллагааны гэрээнд байгуулснаар хүрээлэнгүүд хамтарсан төсөл хэрэгжүүлэх, судлаач эрдэмтэд солилцох, харилцан туршлага судлах, ном сэтгүүл, судалгааны материал солилцох гэх мэт үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс суурь бүрдэж, харилцан ашигтай, үр өгөөжтэй хамтын ажиллагаа хөгжих таатай нөхцөл бололцоо бүрдсэн юм.

Манай төлөөлөгчдийн айлчлалын хөтөлбөрт орсон өөр нэг чухал арга хэмжээ бол 2012 оны 11 сарын 26-28-ны хооронд БНСВУ-ын нийслэл Ханой хотод зохион байгуулагдсан “Вьетнам судлалын олон улсын 4-р хурал”-д оролцох явдал байлаа. Айлчлал хийхээр ирсэн ШУА-ийн албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнээс гадна энэхүү хуралд оролцохоор 4 эрдэмтэн нэмж ирсэнээр ШУА-ийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин тэргүүтэй 12 хүний бүрэлдэхүүнтэй Монголын эрдэмтдийн төлөөлөгчид анх удаа Вьетнам судлалын олон улсын хуралд оролцов. “Вьетнам судлалын олон улсын хурал” нь БНСВУ-ын Ерөнхий сайдын ивээл дор 4 жил тутам зохион байгуулагддаг олон улсын хэмжээний эрдмийн чухал чуулга бөгөөд ба энэ удаагийн 4-р хурал нь “Интеграци, тогтвортой хөгжлийн замаар замнаж буй Вьетнам орон” сэдвийн дор болж өнгөрлөө. Вьетнам судлалын бүхий л асуудлыг хамарсан 15 салбар хуралдаанд нийт 2000 орчим судлаач эрдэмтэд оролцсоны дотор гадаадын 36 орноос 300 гаруй зочид төлөөлөгчид иржээ. Манай улсаас Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор Б.Цогоо, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Л.Цэдэндамба нар “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод дэвшүүлсэн олон улсын хамтын ажиллагааны чиг хандлага”, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор С.Цолмон “XIII-XIV зууны үеийн Монгол-Аннамьн харилцаа Монголын түүх бичлэгт”, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Б.Мөнхбаяр “Монгол, Вьетнамын утга зохиолын туурвил зүйн сэтгэлгээний нийтлэг шинж”, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор, профессор С.Дашцэвэл “Төв Ази болон Зүүн Өмнөд Азийн угсаатны соёлын эртний харилцаа”, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам “Монгол-АСЕАН-ны хооронд харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд Вьетнам улсын үүрэг роль” гэсэн нийт 5 илтгэл бэлтгэн оролцов. Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам 11 сарын 27-ны өдөр “Интеграци, тогтвортой хөгжлийн замаар замнаж буй Вьетнам орны олон улсын харилцаа” сэдэвт 14-р салбар хуралдааны 11 сарын 27-ны өдрийн үдээс хойш болсон хурлыг даргалав. Мөн өдрийн орой Вьетнамын коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга Нгуен Фу Жонг /Nguyen Phu Trong/ “Вьетнам судлалын олон улсын 4-р хурал”-д оролцсон төлөөлөгчдийн төлөөллийг хүлээн авч уулзахад манай улсын ШУА-ийн дэд

ерөнхийлөгч Т.Дорж, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам нар байлцав. Вьетнамын Ерөнхийлөгчтэй хийх уулзалтын үеэр гадаадын 5 орны төлөөлөгчид үг хэлэх боломж олгосны дотор ШУА-ийн дэд ерөнхийлөгч Т.Дорж багтан хоёр орны шинжлэх ухааны байгууллагуудын харилцааны талаар танилцуулж, Вьетнам орны хөгжил цэцэглэл, “Вьетнам судлалын олон улсын 4-р хурал”-ын талаар өөрийн сэтгэгдлээс хуваалцав. Мөн 11-р сарын 28-нд “Вьетнам судлалын олон улсын 4-р хурал”-ын хаалтын нэгдсэн хуралдаан дээр гадаадын 3 төлөөлөгч уригдаж үг хэлсэний нэг нь Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам байв. Энэ бүхэн бол Вьетнамын тал Монголын эрдэмтдийг ихэд хүндэлж чухалчлан үзсэний илрэл хэмээн үзэж байна.

Хоёр Академи хооронд байгуулагдсан гэрээний дагуу эрдэмтэн судлаачийн тэгш солилцоогоор Олон улс судлалын хүрээлэнгийн Солонгос, Зүүн Өмнөд Ази судлалын секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан Б.Цэнгэлхам 2012 оны 11 сарын 14-ээс 2012 оны 12 сарын 06-ны хооронд БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэн дээр судалгааны ажил хийв. Энэ үеэр БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэн, Хятад судлалын хүрээлэн, Социологийн хүрээлэн, Зүүн өмнөд ази судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын ажилтай танилцан, туршлагаас нь суралцаж, номын санд нь ажиллав. Мөн Зүүн хойд ази судлалын хүрээлэнгийн Хойд ази судлалын төвөөс зохион байгуулсан “Монгол Улс” сэдэвт семинарт “Өнөөгийн Монгол” сэдвээр илтгэл бэлтгэн хэлэлцүүлж, Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн өнөөгийн байдал, Монгол орон, монгол хүний зан байдлын талаар тус хүрээлэнгийн судлаачдын сонирхсон асуултанд хариулж, харилцан ярилцав. Тус семинар дээр Зүүн хойд ази судлалын хүрээлэнгийн Хойд Ази судлалын төвийн эрдэмтэн судлаачид “Монгол-Вьетнамын харилцаа”, “Монгол-Тайванийн харилцаа”, “Монгол-Солонгосын харилцаа” сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлж, тус хүрээлэнгийн нийт 52 судлаач оролцов.

Мэдээ бэлтгэсэн Б.Цэнгэлхам